



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 712

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 52 нэрийн, нийт 30,654,600.00 (гучин сая зургаан зуун тавин дөрвөн мянга зургаан зуун) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Н.Пүрэвсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
112 дугаар тогтоолын хавсралт

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ХӨДӨӨ АЖ АХУЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ, ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Хурдны хайрцагны систем болон сэлбэгийн үзүүлэн самбарууд 20ш	2012.09.20	1	3,927,000.00	3,927,000.00
2	Проекторын дэлгэц	2012.12.10	1	180,000.00	180,000.00
3	Зургийн апрад	2012.07.01	2	399,990.00	799,980.00
4	Сүүний шинжилгээний багаж	2012.07.01	1	1,650,000.00	1,650,000.00
5	Хадуур	2010.11.01	1	800,000.00	800,000.00
6	Тармуур	2010.11.01	1	400,000.00	400,000.00
7	Сүү машиндагч	2010.11.01	1	45,000.00	45,000.00
8	Тракторын татлага модель	2010.11.01	1	17,290,000.00	17,290,000.00
9	Слесарийн ширээ	2012.12.27	5	600,000.00	3,000,000.00
10	Менежер сандал	2012.07.01	7	75,000.00	525,000.00
11	Энгийн термостат /аяга таваг хатаагч /	2010.11.01	1	30,000.00	30,000.00
12	Ном	2011.04.01	9	41.00	2,007,620.00
Нийт дүн					30,654,600.00
					(гучин сая нэг зуун тавин дөрвөн мянга зургаан зуун)